



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА
ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Ховд аймгийн Жаргалант сумын Цаст-алтай цогцолбор сургуулийн 2022 оны
санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ХОА-2022/126/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

www.audit.mn

Ховд хот

2023 он

Ховд аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,

тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар

Цахим хаяг: Boldbaatar.Kh @audit.gov.mn

Аудитын менежер: А.Цэцэгсүрэн

Утас: 70432545

Цахим хаяг: tsetsegsuren.a@audit.gov.mn

Аудитор: Ц.Гантулга

Утас: 99911390

цахим хаяг: Oyunjargals@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	12
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	12
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	13
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	14
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд	14
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	15
3.5.1 Төсвийн төлөвлөлт	15
3.5.2 Төсвийн гүйцэтгэл	15
3.5.3 Нэмэлт төсөв	16
4. АУДИТЫН ТАЙЛАН	16
4.1 Ерөнхий зүйл	16
4.2 Материаллаг байдал	16
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	17
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	17
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	17
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	17
4.5.1 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн	17
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	17
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	17
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	17

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт



**ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд
Утас: 976-70433061, Факс: 976-70433061
E-mail: khovd@audit.gov.mn

2023.02.20 № 01/64
танай _____-ны № _____-т

ХОВД АЙМГИЙН ЖАРГАЛАНТ
СУМЫН ЦАСТ-АЛТАЙ ЦОГЦОЛБОР
СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ
Б.БЯМБАСҮРЭН ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Ховд аймгийн Жаргалант сумын Цаст-Алтай цогцолбор сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Ховд аймгийн Жаргалант Цаст-Алтай цогцолбор сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

2022 оны 12 дугаар сарын 22-ны өдөр гэрээний дагуу 11 ширхэг суурин компьютерыг цахим дэлгүүрээс ерөнхий гэрээний дагуу худалдан авалт хийсэн боловч хөрөнгө ирээгүй авлагаар бүртгэсэн байна.

Аудитын гол асуудал

Тайлант хугацаанд Боловсрол шинжлэх ухааны газраас 22.1 сая төгрөгийг сурах бичиг, түрээсийн сурах бичиг, Дэлхийн зөн олон улсын байгууллагаас 2.2 сая, Төгсөгчдийн хандиваар 11.7 сая төгрөгийн тоног төхөөрөмж тавилга эд хогшил, Тулга төхөөрөмж ХХК-аас 20.0 сая төгрөгийн гал тогооны тавилга жижиг хэрэгсэл гэх мэт үнэ төлбөргүйгээр, 89.1 сая төгрөгийн хөрөнгө төсвийн хөрөнгөөр худалдан авсан байна.

Бусад асуудлын хэсэг

Тус сургууль нь 1200 хүүхэд хүлээн авах хүчин чадалтайгаас 2022 онд 47 бүлэгт 1877 хүүхэдтэйгээр 66 багштай, 94 орон тоотойгоор үйл ажиллагаагаа явуулж байна.

2022 онд 3 зорилт 20 арга хэмжээг хэрэгжүүлэхээр гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулан батлуулж, биелэлтийг тооцон Жаргалант сумын Засаг даргад хүргүүлжээ.

Тус сургууль нь 2022 онд 1-5 дугаар ангийн 21 бүлэгт нийт 136788 хүүхэд өдөр үдийн хоол арга хэмжээг хэрэгжүүлж 205.2 сая төгрөгийг зарцуулжээ.

801020180

2022 онд 3 зорилт 20 арга хэмжээг хэрэгжүүлэхээр гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулан батлуулж, биелэлтийг тооцон Жаргалант сумын Засаг даргад хүргүүлжээ.

Тус сургууль нь 2022 онд 1-5 дугаар ангийн 21 бүлэгт нийт 136788 хүүхэд өдөр үдийн хоол арга хэмжээг хэрэгжүүлж 205.2 сая төгрөгийг зарцуулжээ.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага


Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ХҮНДЭТГЭСЭН: ДАРГА,

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:



Х.БОЛДБААТАР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	/Төгрөгөөр/	
		Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	201,472,707.61	330,647,928.22
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	74,184,326.89
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	-	74,184,326.89
3121	Төгрөг	-	74,184,326.89
31211	Төрийн сангийн харилцах	-	74,184,326.89
3471	Урьдчилгаа тооцоо	13,000,000.00	0.00
34600	Урьдчилж төлсөн зардал	13,000,000.00	49,233,470.00
35	БАРАА МАТЕРИАЛ	188,472,707.61	207,230,131.33
351	Түүхий эд материал	6,557,948.00	3,585,860.00
35130	Эм боох материал	6,557,948.00	3,585,860.00
35200	Дуусаагүй үйлдвэрлэл	900,000.00	900,000.00
35300	Бэлэн бүтээгдэхүүн	115,000.00	115,000.00
354	Хангамжийн материал	180,899,759.61	202,629,271.33
35410	Бичиг хэргийн материал	5,584,191.00	9,190,294.00
35420	Аж ахуйн материал	24,351,777.00	19,614,217.00
35430	Сэлбэг хэрэгсэл	399,255.00	399,255.00
35440	Түлш, шатах тослох материал	-	69,850.00
35470	Бусад хангамжийн материал	150,564,536.61	173,355,655.33
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	6,236,435,594.65	6,115,636,920.86
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	6,236,435,594.65	6,115,636,920.86
392	Биет хөрөнгө	5,932,947,844.75	5,812,192,920.86
39201	Барилга, байгууламж, орон сууц	5,959,943,286.43	5,959,943,286.43
39202	Хуримтлагдсан элэгдэл	(259,437,922.45)	(433,404,493.83)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	236,340,703.68	329,206,703.68
39206	Хуримтлагдсан элэгдэл	(160,226,459.69)	(197,111,345.03)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	193,202,768.42	222,883,548.42
39208	Хуримтлагдсан элэгдэл	(69,774,468.58)	(112,415,572.85)
39217	Ном	32,899,936.94	43,090,794.04
393	Биет бус хөрөнгө	303,487,749.90	303,444,000.00
39301	Програм хангамж	1,461,600.00	1,461,600.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,417,850.10)	(1,461,600.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	303,444,000.00	303,444,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	6,437,908,302.26	6,446,284,849.08
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	6,437,908,302.26	6,446,284,849.08
51	Засгийн газрын хувь оролцоо	6,437,908,302.26	6,446,284,849.08
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,146,187,550.49	1,146,187,550.49
51101	Өмч: - төрийн	1,146,187,550.49	1,146,187,550.49
512	Хуримтлагдсан үр дүн	4,374,174,179.68	4,382,550,726.50
51210	Өмнөх үеийн үр дүн	4,374,174,179.68	4,374,174,179.68
51220	Тайлант үеийн үр дүн	-	8,376,546.82
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	917,546,572.09	917,546,572.09

6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>6,437,908,302.26</u>	<u>6,446,284,849.08</u>
---	--	-------------------------	-------------------------

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл /Төгрөгөөр/
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,919,423,325.95	2,838,580,171.76
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	32,951,776.95	69,326,971.76
120	Нийтлэг татварын бус орлого	32,951,776.95	69,326,971.76
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	32,951,776.95	69,326,971.76
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	3,568,830.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	798,000.00	7,442,650.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	32,153,776.95	58,315,491.76
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,886,471,549.00	2,769,253,200.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,516,194,700.00	2,370,773,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	2,370,773,500.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,516,194,700.00	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	53,390,092.00	-
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	11,954,900.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	41,435,192.00	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	302,470,900.00	398,479,700.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	302,470,900.00	398,479,700.00
1330	Төсвийн захирагчдаас	14,129,550.00	-
133004	Төсвийн ерөнхийлөн захирагчаас олгосон санхүүжилт	14,129,550.00	-
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	286,307.00	-
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	286,307.00	-
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,989,847,652.02	2,830,203,624.94
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,989,847,652.02	2,830,203,624.94
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,900,314,367.02	2,603,145,444.94
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,251,002,138.00	1,700,275,825.00
210101	Үндсэн цалин	767,055,000.00	1,106,204,507.00
210102	Нэмэгдэл	418,426,865.00	465,253,627.00
210104	Урамшуулал	65,520,273.00	128,817,691.00

2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	168,910,100.00	211,406,368.11
210201	Тэтгэврийн даатгал	123,924,299.71	145,013,513.59
210202	Тэтгэмжийн даатгал	11,596,724.82	17,001,612.57
210203	ҮОМШӨ-ний даатгал	9,249,563.24	13,600,192.92
210204	Ажилгүйдлийн даатгал	2,191,228.50	3,178,976.52
210205	Эрүүл мэндийн даатгал	21,948,283.73	32,612,072.51
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	305,632,805.00	339,631,784.00
210301	Гэрэл, цахилгаан	7,019,405.00	10,790,952.00
210302	Түлш, халаалт	260,761,340.00	287,920,132.00
210303	Цэвэр, бохир ус	37,852,060.00	40,920,700.00
2104	Хангамж, бараа материалын зардал	8,659,311.00	10,594,625.94
210401	Бичиг хэрэг	4,710,450.00	-
210402	Тээвэр, шатахуун	108,900.00	-
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,416,511.00	-
210404	Ном, хэвлэл	17,500.00	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,891,590.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	483,860.00	10,594,625.94
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	30,500.00	-
2105	Нормативт зардал	3,575,461.00	6,441,088.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,538,361.00	3,615,088.00
210502	Хоол, хүнс	-	2,826,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,037,100.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,511,680.00	4,252,050.00
210604	Урсгал засвар	5,511,680.00	4,252,050.00
2107	Томилолт, зочны зардал	320,000.00	-
210702	Дотоод албан томилолт	320,000.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,206,000.00	5,834,530.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	198,000.00	3,561,130.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,008,000.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	2,273,400.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	155,496,872.02	324,709,173.89
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	47,813,516.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,554,640.00	23,359,347.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	150,942,232.02	253,536,310.89
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	89,533,285.00	227,058,180.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	89,142,323.00	227,058,180.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	286,307.00	-
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	54,925,800.00	202,356,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	6,110,100.00	-
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	27,820,116.00	-

213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	24,702,180.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	390,962.00	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	390,962.00	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>(70,424,326.07)</u>	<u>8,376,546.82</u>
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	30,598,335.71	-
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	30,598,335.71	-
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(30,598,335.71)	-
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>(101,022,661.78)</u>	<u>8,376,546.82</u>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>1,887,071,549.00</u>	<u>2,780,264,680.00</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	600,000.00	11,011,480.00
120	Нийтлэг татварын бус орлого	600,000.00	11,011,480.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	600,000.00	11,011,480.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	3,568,830.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	600,000.00	7,442,650.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛГИЙН ОРЛОГО	1,886,471,549.00	2,769,253,200.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,516,194,700.00	2,370,773,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	2,370,773,500.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,516,194,700.00	-
131009	Оны эхний үлдэгдлээс санхүүжих		
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	53,390,092.00	-
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	11,954,900.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	41,435,192.00	-
131106	Төсвийн урамшуулал		
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	302,470,900.00	398,479,700.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	302,470,900.00	398,479,700.00
1330	Төсвийн захирагчдаас	14,129,550.00	-
133004	Төсвийн ерөнхийлөн захирагчаас олгосон санхүүжилт	14,129,550.00	-

1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	286,307.00	-
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	286,307.00	-
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>1,872,941,999.00</u>	<u>2,706,080,353.11</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,872,941,999.00	2,706,080,353.11
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,789,518,814.00	2,476,301,153.11
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,251,002,138.00	1,700,406,863.11
210101	Үндсэн цалин	767,055,000.00	1,107,390,421.11
210102	Нэмэгдэл	418,426,865.00	464,358,226.00
210104	Урамшуулал	65,520,273.00	128,658,216.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	168,910,100.00	211,275,330.00
210201	Тэтгэврийн даатгал	118,862,699.46	144,641,912.33
210202	Тэтгэмжийн даатгал	12,511,900.00	16,935,730.08
210203	ҮОМШӨ-ний даатгал	10,009,500.00	13,677,563.99
210204	Ажилгүйдлийн даатгал	2,502,400.00	3,274,573.97
210205	Эрүүл мэндийн даатгал	25,023,600.54	32,745,549.63
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	308,464,989.00	339,582,700.00
210301	Гэрэл, цахилгаан	8,618,389.00	10,739,600.00
210302	Түлш, халаалт	260,761,340.00	287,922,400.00
210303	Цэвэр, бохир ус	39,085,260.00	40,920,700.00
2104	Хангамж, бараа материалын зардал	13,606,347.00	-
210401	Бичиг хэрэг	3,681,376.00	-
210402	Тээвэр, шатахуун	172,600.00	-
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,416,511.00	-
210404	Ном, хэвлэл	661,200.00	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,633,260.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,041,400.00	-
2105	Нормативт зардал	7,351,700.00	-
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	3,254,800.00	-
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	4,096,900.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,953,200.00	13,348,900.00
210604	Урсгал засвар	5,953,200.00	13,348,900.00
2107	Томилолт, зочны зардал	320,000.00	-
210702	Дотоод албан томилолт	320,000.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	11,608,040.00	22,711,310.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	10,600,040.00	3,790,410.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,008,000.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	18,920,900.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	22,302,300.00	188,976,050.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	13,600,000.00	160,594,650.00

210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	8,702,300.00	28,381,400.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	83,423,185.00	229,779,200.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	83,032,223.00	229,779,200.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	286,307.00	-
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	54,925,800.00	205,182,000.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	27,820,116.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	24,597,200.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	390,962.00	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	390,962.00	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>14,129,550.00</u>	<u>74,184,326.89</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	14,129,550.00	74,184,326.89
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	74,184,326.89

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,146,187,550.49	917,836,813.45	4,482,895,550.10	6,546,919,914.04
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	290,241.36	290,241.36
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,146,187,550.49	917,836,813.45	4,483,185,791.46	6,547,210,155.40
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	(290,241.36)	-	(290,241.36)
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	(109,011,611.78)	(109,011,611.78)
C08	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,146,187,550.49	917,546,572.09	4,374,174,179.68	6,437,908,302.26
D01	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1,146,187,550.49	917,546,572.09	4,374,174,179.68	6,437,908,302.26

D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,146,187,550.49	917,546,572.09	4,374,174,179.68	6,437,908,302.26
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	8,376,546.82	8,376,546.82
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,146,187,550.49	917,546,572.09	4,382,550,726.50	6,446,284,849.08

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2692875000.00	2695919953.11
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2692875000.00	2695919953.11
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2458840300.00	2466140753.11
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1677273900.00	1700406863.11
210101	Үндсэн цалин	1229529000.00	1106513789.11
210102	Нэмэгдэл	409399200.00	465234858.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт		
210104	Урамшуулал	38345700.00	128658216.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	209659300.00	211275330.00
210201	Тэтгэврийн даатгал	142568200.00	144641912.33
210202	Тэтгэмжийн даатгал	16691800.00	16935730.08
210203	ҮОМШӨ-ний даатгал	13499200.00	13677563.99
210204	Ажилгүйдлийн даатгал	3354600.00	3274573.97
210205	Эрүүл мэндийн даатгал	33545500.00	32745549.63
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	339582700.00	339582700.00
210301	Гэрэл, цахилгаан	10739600.00	10739600.00
210302	Түлш, халаалт	287922400.00	287922400.00
210303	Цэвэр, бохир ус	40920700.00	40920700.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	13,348,900.00	13,348,900.00
210604	Урсгал засвар	13,348,900.00	13,348,900.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	26,000,900.00	22,534,380.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	7,080,000.00	3,613,480.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	18,920,900.00	18,920,900.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	192,974,600.00	178,992,580.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	164,593,200.00	150,611,180.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	28,381,400.00	28,381,400.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	234,034,700.00	229,779,200.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	234,034,700.00	229,779,200.00

213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	209,437,500.00	205,182,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	24,597,200.00	24,597,200.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,777,189,750.00	2,777,189,750.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	2,370,773,500.00	2,370,773,500.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	2,370,773,500.00	2,370,773,500.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	398,479,700.00	398,479,700.00
132001	Орон нутгийн төсвөөс	398,479,700.00	398,479,700.00
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	7,936,550.00	7,936,550.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,391,900.00	3,391,900.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,544,650.00	4,544,650.00
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		74,184,326.89
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	90.00	90.00
620001	Удирдах ажилтан	1.00	1.00
620002	Гүйцэтгэх ажилтан	67.00	67.00
620003	Үйлчлэх ажилтан	22.00	22.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Нэмэлт дансаар гүйлгээ хийгдээгүй байна.

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Ховд аймгийн Жаргалант сумын Цаст-Алтай цогцолбор сургууль нь 2022 оны хичээлийн жилийг “Сурагчдын хөгжил төлөвшлийг дэмжиж, ахиц гаргахад сургууль багш эцэг эх олон нийтийн хамтын ажиллагааг өргөжүүлэх, сургалтын үйл ажиллагааг чанаржуулах” гэсэн зорилго дэвшүүлэн ажиллаж байна. Энэхүү зорилгынхоо хүрээнд “Багшийн хөгжлийг дэмжих”, “Хүүхдийн хөгжил төлөвшлийг дэмжих”, “Хамтын оролцоог нэмэгдүүлэх гэсэн тэргүүлэх зорилт тавин ажиллажээ.

Цаст-Алтай цогцолбор сургууль нь 4 заах аргын нэгдэлд сургалт бусад үйл ажиллагаа явуулдаг ба байгалийн ухааны заах аргын нэгдэлд-20, нийгмийн ухааны заах аргын нэгдэлд -25, бага ангийн заах аргын нэгдэлд-21, захиргаа аж ахуйн заах аргын нэгдэлд-28, нийт 94 багш ажилтантайгаар үйл ажиллагаагаа явуулж байна.

Тус сургууль нь бага ангийн-21, дунд, ахлах ангийн-44 багштай. Зөвлөх 3, тэргүүлэх 38, заах аргач 17, зэрэггүй 8 нийт багш нарын 87.8 % нь мэргэжлийн зэрэгтэй, 53 багш бакалавр, 13 багш магистр зэрэгтэй байна. Нийт багш нар 100% багшлах эрхтэй.

2022 онд хийсэн багшийн гүйцэтгэлийн үнэлгээгээр I түвшний багш-4, II түвшний багш -10, III түвшний багш -9, бусад IV түвшний 11, бусад багш нар V,VI түвшинд шалгагдсан ба нийт оноогоор 75.6% авч аймгийн дунджаас 5.7%, улсын дунджаас 3.1% ахисан амжилтыг үзүүлжээ.

Жаргалант сумын Цаст-Алтай цогцолбор сургуульд 2022-2023 оны хичээлийн жилд 1 дүгээр ангид 198 сурагч элсэж, 47 бүлэгт 1877 сурагч суралцаж, анги дүүргэлтийн дундаж 40.0 ба бага анги буюу 1-5 дугаар ангийн 21 бүлэгт 966, дунд анги буюу 6-9 дүгээр ангийн 16 бүлэгт 598, ахлах анги буюу 10-12 дугаар ангийн 10 бүлэгт 313 сурагч суралцаж байна. Нийт шилжиж ирсэн 55, шилжиж явсан 40 сурагч байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллага нь үйл ажиллагаандаа Бага дунд боловсролын тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Татварын тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хуулийг мөрдөн ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Тухайлбал:

- “Хувьсах зардлын дундаж норматив тогтоох тухай” Засгийн газрын 2022 оны 91 дүгээр тогтоол;
- “Хичээл, сургалтын үйл ажиллагаа, Багшийн тасралтгүй хөгжил, цахим хэрэглээ, тоног төхөөрөмж нөхөн хангалт батлах тухай” Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2022 оны А/170 дугаар тушаал;
- “Ерөнхий боловсролын сургуульд кабинет, лаборатори, цахим сургалтын танхим байгуулах, ашиглах тухай журам” Боловсрол, шинжлэх ухааны сайдын А/465 дугаар тушаал;
- “Төрийн болон орон нутгийн өмчийн сургууль, цэцэрлэгийн үйл ажиллагааны гүйцэтгэлийн чанар үр дүн үнэлж, үр дүнгийн урамшуулал олгох журам” Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2022 оны А/500 дугаар тушаал;
- Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль/дотуур байрын хүүхдэд хоол, хүнсний хангамж, үйлчилгээ үзүүлэхэд мөрдөх журам” БСШУЯ-ны А/59 тушаал тус тус шинэчлэгдэн баталсан байна.

Тайлант онд БШУЯ-ны дотоод аудитын алба болон аймгийн ЗДТГ-ын Санхүү, дотоод аудитын албанаас тус сургуулийн 2022 оны үйл ажиллагаанд хяналт шалгалт хийгээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

Боловсролын байгууллагын багш ажилтанд үр дүнгийн урамшуулал, ур чадварын нэмэгдэл олгох журмуудад өөрчлөлт орсон байна. 2022 онд боловсролын байгууллагын сургалтын үйл ажиллагааны зардлыг төлөвлөх, хуваарилах, багшийн хөгжлийг дэмжих, цахим хэрэглээний зардлыг төлөвлөх, тоног төхөөрөмжийн нөхөн хангалтын зардлыг төлөвлөх, хуваарилах, санхүүжүүлэх, багшийн тасралтгүй хөгжлийг дэмжих үйл ажиллагааны санхүүжилт, түүнийг зарцуулах журмыг шинээр баталжээ.

2022 онд Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2022 оны 02 дугаар 22-ны өдрийн 64 дүгээр тогтоолын дагуу Жаргалант сумын Цаст-Алтай цогцолбор сургуулийн захирлын 2022 оны 05 дугаар сарын 12-ны А/28 дүгээр тушаалаар төрийн болон орон нутгийн өмчийн улсын үзлэг, тооллогын ажлыг зохион байгуулах ажлын хэсэг 6 хүний бүрэлдэхүүнтэйгээр томилж, тооллогыг зохион байгуулж хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, бүрэн бүтэн байдалд хяналт тавих ажлуудыг зохион байгуулсан байна.

Байгууллагын захирлын 2022 оны 10 дугаар сарын 12-ний өдрийн А/85 тоот тушаалаар 13 хүний бүрэлдэхүүнтэй эрсдэлийн үнэлгээний ажлын хэсэг байгуулагдаж уг ажлын хэсэг бүх анги танхим, өрөө тасалгаа, коридорын шинээр хийсэн дүүжин таазыг авч үзэж, бодит байдлыг зургаар баталгаажуулан нийт нурааж засварлах таазны талбайн хэмжээг тооцож, эрсдэлийн үнэлгээ хийсэн.

Тус хичээлийн байр нь 1959 онд баригдсан ашиглалтын хугацаа дууссан он удаан жилийн ашиглалт, цаг үеийн халаалт, ус чийг, анги дүүргэлт хүүхдийн тоо /40-49/ хөдөлгөөний ачааллаас болж таазны гоёлын хүрээ /хагас релеп/ ан цав үүсэж хөндийрч унасан .

Иймээс хүүхдийн суралцах аюулгүй орчин бүрдүүлж тус гоёлын хүрээг нурааж авах , засварлах шаардлагатай мэт шалтгаан нөлөөлсөн гэж үзжээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Жаргалант сумын Цаст-Алтай цогцолбор сургууль нь 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Жаргалант сумын Цаст-Алтай цогцолбор сургуулийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 209.84 сая төгрөгөөр буюу 3.3 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/сая. төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгө		74.18	74.18
Авлага	13.0	49.23	36.23
Бараа материал	188.47	207.23	18.76
Үндсэн хөрөнгө	6236.4	6115.6	(120.9)
Нийт хөрөнгө	6236.44	6446.28	209.84
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	6437.91	6446.28	8.38
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	6437.91	6446.28	8.38

Дээрх хүснэгтээс харахад Ховд аймгийн Жаргалант сумын Цаст-Алтай цогцолбор сургуулийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн

өмнөх оноос 209.84 мянган төгрөгөөр өссөний материаллаг нөлөө нь мөнгөн хөрөнгө, бараа материал, үндсэн хөрөнгийн данстай холбоотой байна.

- ✓ Сангийн яамны 2022 оны 12 дугаар сарын 25 өдрийн 18 дугаартай албан бичгээр хүргүүлсэн чиглэлийн дагуу мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 74.1 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.
- ✓ Авлага 36.2 сая төгрөгөөр нэмэгдсэн нь БШУС-ын тушаалын дагуу тоног төхөөрөмжийн нөхөн хангалтаар суурин компьютер худалдан авсантай холбоотой байна .
- ✓ Бараа материал 18.76 сая төгрөгөөр нэмэгдсэн нь БШУЯ-аас түрээсийн сурах бичиг нийлүүлсэн болно.
- ✓ Үндсэн хөрөнгө 120.9 сая төгрөгөөр буурсан нь үндсэн хөрөнгийн элэгдэлтэй холбоотой байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 2370.8 сая, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос 11.1 сая , орон нутгийн төсвөөс 398.5. сая нийт зарлагыг 2780.2 сая төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлэн батлагдсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд улсын төсвөөс 2370.7 сая, орон нутгийн төсвөөс 398.5, үндсэн үйл ажиллагааны орлогоос 11.0 сая төгрөг нийт 2780.2 сая төгрөг гүйцэтгэлээр санхүүжиж 2,706.1 сая төгрөгийг зориулалтын дагуу зарцуулж 74.1 сая төгрөгийн төсвийг хэмнэж гүйцэтгэлээр санхүүжиж байгаатай холбоотой 74.1 сая төгрөгийн дансны үлдэгдэлтэй байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2706.1 сая төгрөг 97 хувьтай байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	71802/80226-тогтмол зардал	7,568.4	7,568.4	-	100%
2	71802/80312-сургалт семинар	3,784.2	3,784.2	-	100%
3	70802/81801 -үдийн цай	209,437.8	205,182.0	4,255.50	98%
4	70802/81605-Эрүүл мэнд	8,703.6	4,882.0	3,821.6	56%
5	71802/81816-Нөхөн хангалт	97,405.0	97,405.0	-	100%
6	71802/81823-Боловсролын байгууллагын багш	17,028.8	17,028.7	-	100%
7	71802/81834-Үндсэн цалин	1,898,148.1	1,832,504.7	65,643.4	97%
8	71802/81835-Сургалтын хэвийн үйл ажиллагаа	128,698.1	128,234.3	463.7	99%
9	71802/81844-Гүнзгийрүүлсэн болон төрөлжсөн	7,398.0	7,398.0	-	100%

10	71802/81848 сурах бичгийн түрээс	3,613.4	3,613.4	-	100%
11	71802/80111-тогтмол зардал	352,931.5	352,931.5	-	100%
12	71802/80112-нийтлэг үйлчилгээ	45,548.2	45,548.2	-	100%
ДҮН		2,780,264.6	2,709,547.0	74,184.2	96%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар түрээсийн номын төлбөр 3.3 сая төгрөг орж ирснийг үндсэн данс руу шилжүүлж зориулалтын дагуу зарцуулсан тул нэмэлт төсвийн тайлан гаргаагүй

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Ховд аймгийн Жаргалант Цаст-Алтай цогцолбор Гуравдугаар сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг аудитор Ц.Гантулга 2023 оны 02 дугаар сарын 18-ний өдрөөс 02 дүгээр сарын 20-ны хооронд гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер А.Цэцэгсүрэн, газрын дарга, тэргүүлэх аудитор Х.Болдбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Тус байгууллага нь 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 63 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны орлого үр дүнгийн тайлангийн нийт зардлын 2695,9 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 40.4 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 32.3 сая төгрөгөөр тогтоосон.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага хуулиар хориглосон зардлуудыг санхүүжүүлээгүй байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим системд таван саяас дээш орлогын гүйлгээг мэдээлээгүй, байсныг аудитын явцад залруулан мэдээлүүлээ.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар Засгийн газрын 43 дугаар тогтоолын дагуу батлагдсан төсөвт зардлын 10 хувиас доошгүй хувийн хэмнэлт гаргаагүй, төсөвт төвлөрүүлээгүйтэй холбоотой 139.0 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж өгснийг хэрэгжүүлэн ажилласан байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	1	181.4	1	181.4	100.0
Нийт дүн	1	181.4	1	181.4	100

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах эрсдэлтэй асуудал гараагүй болно.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар 0.9 сая төгрөгийн давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өглөө.

5.1.Зөвлөмж

5.1.1 Түрээсийн гэрээтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Сургуулийн цайны газрыг “Ховд-Скай” ХХК-нд түрээслүүлсний орлого 900.0 мянган төгрөгийг дутуу төвлөрүүлсэн, төвлөрүүлсэн орлогын 40 хувийг улсын төсөвт бүрэн шилжүүлээгүй байгаа нь захирлын “Хамтран ажиллах тухай” 01 тоот гэрээний гуравдугаар зүйлийн 3.1. “Түрээсийн төлбөр сар 300000 төгрөг” , Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын тогтоолын 49 дүгээр зүйлийн 49.2. “Түрээсийн орлогоос улсын төсөвт төвлөрүүлэх хэмжээг нийт орлогын дүнгийн 40 хувиар тогтоосугай” гэсэн заалтууд, “Үнэн зөв байдал”, “Иж бүрэн” байх гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж Хичээлийн жилд багтаан дээрх гэрээ, тогтоолын заалтын дагуу түрээсийн орлогыг бүрэн төвлөрүүлж зохих хувийг нь улсын төсөвт шилжүүлэх

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/сая төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруула агүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Түрээсийн гэрээ	1	0.9									1	0.9
Дүн	1	0.9									1	0.9

АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:  Х.БОЛДБААТАР

АУДИТЫН МЕНЕЖЕР:  А.ЦЭЦЭГСҮРЭН

ТАЙЛАНГ БИЧСЭН: 

АУДИТОР: 

Ц.ГАНТУЛГА